# Аймгийн Намын Хороо, АДХ—ын Гүйцэтгэх Захиргаанд

Аймгийн Намын Хороо, АДХГ Захиргаа саяхан бог мал хээлтүүлэгийн ажлыг хэрхэн хангаж байгааг Лүн, Угтаал, Бүрэн суманд шалгасан дүнг авч хэлэлцээд бог мал хээлтүүлгийг зохион явуулах тухай тодорхой заалт бүхий тогтоол гаргав.

Уг тогтоолд бог малын нөхөн үйлдвэрлэлийг хангах үндсэн нөхцлийн нэг бол хээлтүүлэгийг цаг алдалгүй эхлэж богино хугацаанд чанартай дуусгах явдал мөн. Өнгөрсөн онд бог мал хээлтүүлэгийг Баянцагаан, Баян, Баянбараат, Дэлгэрхаан, Эрдэнэ, Баяндэлгэр сумууд бэлтгэл зохион байгуулалтгүй, хээлтүүлэгийг оройтуулан эхлэж урсгалаар нь явуулж байсны гадна ялангуяа Баяндэлгэр сум зохиомол хээлтүүлэгийг ор нэр болгон маш хариуцлагагүй хийж төлөвлөгөөг тасалдуулж байжээ.

Түүгээр ч барахгүй Эрдэнэ суманд эрлийз хонины бүтэн суурьт зохиомол хээлтүүлэг хийгээгүй өнгөрсөн байна.

Одоогийн байдлаар энэ онд бог мал хээлтүүлэх ажил эхлэх хугацаа болоод байхад Угтаал Лүн, Баянбараат, Бүрэн зэрэг нилээд сумууд хээлтүүлэгийн бэлтгэлийг бүрэн хангаагүй монгол хуц ухна олон тоогоор дутагдаж байхад байгаа хуц, ухнаа нэмэгдэл тэжээлд оруулаагүй зохиомол хээлтүүлэгт ашиглах хуц ухныхаа үрийг авч шинжлэх тохируулан сонголт хийх ажлуудыг хийгээгүй түүгээр ч барахгүй Баян, Өнжүүл, Бүрэнгийн нэгдлүүд энэ оны хээлтүүлэгт ашиглах сайн үүлдрийн хуцыг одоо болтол татаж аваагүй байгаа нь өнгөрсөн жилийнхээ дутагдлыг давтахад хүрч байна.

Түүнчлэн нам, улсын хариуцлагатан мал аж ахуйн мэргэжилтнүүдийг энэ ажилд дайчлан оруулаагүй байгаагаас энэ чухал үйлдвэрлэлээс хөндий тасархай байна.

Иймд бог мал хээлтүүлэгийн бэлтгэлийг хангаж уг ажлаа зохион байгуулалттай яаравчлан эхлэж богино хугацаанд чанартай явуулах нь манай аймгийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн ажиллагааны энэ жилийн байдал 4 дүгээр таван жилийн төлөвлөгөөний зорилтоос үндэслэж эдийн засгийн талаар үлэмж илүү шаардагдаж байна гэж тэмдэглээд аймгийн хэмжээгээр хонийг 2 дугаар сарын 25—наас, ямааг 3 дугаар сарын 10—наас эхлэн төллүүлэхээр бодож хонийг 9 дүгээр сарын 25—наас, ямааг 10 дугаар сарын 15—наас тус тус эхлэн хээлтүүлж бог мал хээлтүүлэгийг 45 хоногт багтаан дуусгахаар тогтоожээ.

Мөн бог мал хээлтүүлэгийн бэлтгэл ажлын дутууг 9 дүгээр сарын 25—ны дотор бүрэн хангаж уг ажлыг сумын хэмжээгээр нарийн зохион байгуулалттай зэрэг эхлүүлэх, аймгийн хэмжээгээр зарим хэсэгт ердийн хээлтүүлэгээр хээлтүүлэх хонь ямааны суурьт ноогдох хуц ухныг ашиглаж байгаа өдөрт нь нэг тэжээлийн нэгж, завсарлаж амарч байгаа үед нь 1,5—аас доошгүй тэжээлийн нэгжээр нэмэгдлээр тэжээж 7,7 хоногоор ээлжлэн тавьж ашиглан, ердийн хээлтүүлэгийг зөвхөн хэсэгчлэн хээлтүүлэх аргаар зохион байгуулалттай явуулж дуусгах, Ердийн хээлтүүлэгт хэрэглэх хуц ухныг 2 хэсэг болгон ээлжлэн хээлтүүлэгт ашиглах болсонтой холбогдуулж 5—10 суурийн дунд хашаа байр тэжээл бүхий тусгай цэг байгуулж түүнд хуц, ухна маллагч 1—ийг гаргаж ажиллуулах, хээлтүүлэгт шаардагдаж буй хуц, ухныг шөнийн цагт эм хонь ямаанаас тусгаарлан нэмэгдэл тэжээл өгч амраагаад өглөө эрт тавьж байх, зохиомол хээлтүүлэгт ашиглах бүх хуцны үрийг хуурай шингэлэгчээр шингэлж хэрэглэн нэг хуц, ухнаар 450—аас доошгүй эм хонь, ямаа хээлтүүлэх, ирэх оны төл бойжуулах хүн хүчний зарим шаардлагаас үндэслэн зохиомол хээлтүүлгийн салбарт хамрагдаж байгаа бүх сууриудад 5—аас дээшгүй хоногийн зайтайгаар хээлтүүлэгийг явуулах, бог мал хээлтүүлгийн ажилд мал аж ахуйн мэргэжилтэн нарыг бүрэн оролцуулж зохиомол хээлтүүлэгийн салбар ба хээлтэх хонь, ямааны суурийг дээд, дунд мэргэжлийн зоотехникч нараар биечлэн хариуцуулж ажиллуулах, бог мал хээлтүүлэгийн үеэр бригад суурь малчдын дунд социалист уралдааныг өрнүүлэн ажиллуулж 7 хоног дутам дүгнэж байх, бог мал хээлтүүлэгийн ажлыг хэрхэн эхлэж явуулсан тухай 10 дугаар сарын 3-нд аймгийн намын хороо, АДХГЗахиргаанд тодорхой илтгэх хуудсаар мэдэгдэх, энэ тогтоолыг сумын намын үүрийн товчоо, АДХГ Захиргааны гишүүдийн өргөтгөсөн хурлаар мал аж ахуйн мэргэжилтнүүд бригад хэсгийн ахлагч нарыг байлцуулан хэлэлцэж тодорхой төлөвлөгөө гарган ажиллах, бог мал бүрийг хээл авахуулахын эдийн засгийн ач холбогдлыг өргөн сурталчлахын хамт зохиомол хээлтүүлэгийн салбаруудад туг дарцаг, ухуулах хуудас, лозун, плакадаар хангах, бог мал хээлтүүлэгийн явц чанар, зохион байгуулалтанд тогтмол хяналт шалгалт явуулах, оршиж байгаа дутагдлыг цаг тухайд нь засаж байх, энэ ажилд нам төрийн хяналтад туслах ОНХШ комиссыг өргөнөөр татан оруулж ажиллуулах, бог мал хээлтүүлэгийн үед хөтлөгдөх бүртгэл тооцоог үнэн зөв хөтлөж мэдээ судалгааг цаг тухайд нь гаргаж байх, бог мал хээлтүүлэгийн компанит ажилд эвлэл, үйлдвэрчин, эмэгтэйчүүд зэрэг олон нийтийн байгууллагуудын хүчийг жигдрүүлэн зохион байгуулж тэднээс явуулах соёл олон түмний ажлыг энэ ажилтай уялдуулан зохиохыг сумдын намын үүр, хороод АДХГ Захиргаа, ҮЗХстанцын дарга нарт даалгажээ. Түүнчлэн бог малын зохиомол хээлтүүлэгт шаардагдах багаж хэрэгсэл эм ариутгалын зүйлийн дутууг 9 дүгээр сарын 20-ны наана олж бэлтгэн сумдыг хангах, бог мал хээлтүүлэгийн явцыг газар дээр нь шалгаж тодорхой заавар удирдамжаар хангаж байх, бог мал, хээлтүүлэгийг явуулах аргачилсан хөтөлбөр хүн нэг бүрийн эрхлэх ажил гүйцэтгэх үүргийг тодорхойлсон даалгавар өгч дүнг 11 дүгээр сарын 10-нд хүн нэг бүр дээр гаргаж намын хороо, АДХГ Захиргаанд илтгэх, бог малын хээлтүүлэгт ажиллах зоо техникч дутагдалтай Өнжүүл, Баянжаргалан Эрдэнэсант зэрэг сумдад хонь голлон үржүүлээгүй сумууд болон зарим ҮЗХ станцуудын зоо-техникчдийг хээлтүүлэг дуустал 45 хоногийн хугацаагаар томилолтоор ажиллуулахыг ХАА Удирдах газар (н.Баянзрагчид) даалгасан байна.

Бог мал бүрэн хээл авахуулах ажилд гарч байгаа тэргүүн туршлага ажлын ололт дутагдлуудыг өргөн хэвлэж байх тусгай булан гаргаж 9 дүгээр сарын 25-наас эхлэн 45 хоногийн хугацаагаар ажиллуулахыг «Анхдугаар таван жил» сонины газар(н.Мөнхөөд) даалгажээ.

# НАМЫН ГЭГЭЭРЛИЙН АЖИЛ

МАХН—ын улс төрийн бодлого үйл ажиллагааны үндэс болсон марксист—ленинист онолыг өөрийн орны өвөрмөц нөхцөлд бүтээлчээр хэрэглэж намын бүх гишүүд хөдөлмөрчдийг онолын мэдлэгээр зэвсэглэх явдал социализм амжилттай байгуулах зайлшгүй чухал нөхцөл мөн гэж МАХН—ын XV их хурал заасан билээ. 1965—66 оны хичээлийн жилд аймгийн төв хөдөөд 60 гаруй дугуйлан онолын семинар байгуулагдан 1500 гаруй сонсогчдыг хамарч жилийн эцсийн шалгалтаар нийт дугуйлан онолын семинарт оролцогчид 99,8 хувийн сурлагын амжилт үзүүлснийн дотор дугуйлангийн сонсогчдын 50 гаруй хувь, онолын семинарын сонсогчдын 60 гаруй хувь нь онц ба сайн дүнтэй суралцав.

1965—66 оны хичээлийн жилийн байдлаас үзвэл Баянцогтын сангийн аж ахуйн намын хороо, Бүрэн сумын намын үүр зэрэг газрууд намын кабинет шинээр байгуулж ажилласан ба Жаргалантын сангийн аж ахуйн намын хороо, Загдал, Талбулагийн тасгуудад намын ажлын тасалгаа бий болгож суртал нэвтрүүлэгчид сонсогчдод туслах тэдэнд зориулан үзүүлэн таниулах самбар хичээлд холбогдох номын жагсаалт булан гарган ажиллажээ. Мөн суртал нэвтрүүлэгчдийн дотор өөрсдийн зааж байгаа хичээлийг урьдаас сайн бэлдэж орчин үеийн байдалтай холбож сонсогчдод гүн бат мэдлэг олгохын төлөө чармайн ажилладаг суртал нэвтрүүлэгчид олширч байна. Намын гэгээрлийн ажилд ахиц гарч байгаа боловч үлэмж дутагдал байна. Зарим намын үүр хороод дугуйлан семинарт гишүүдээ хувиарласнаар санаа амарч хүн нэг бүртэй тэднээс дугуйланд оролцож байгаа байдалтай танилцаж тодорхой ажиллахгүй суртал нэвтрүүлэгч нарын хичээлийн заалтанд тавих хяналт шалгалт сул байв.

Өнгөрсөн хичээлийн жилд гарч байсан дутагдлаа дахин давтахгүй байхад намын үүр, хороод ихээхэн анхаарах хэрэгтэй.

Одоо удахгүй эхлэх гэж байгаа 1966—67 оны хичээлийн жилд улс төрийн 3 шатны дугуйлан онолын семинарт намын гишүүд, орлогчид гишүүдээс гадна нам бус идэвхитэн сэхээтэн боловсон хүчнийг өргөн хамруулах юм. Намын гишүүд орлогч гишүүдийн эрхлэн буй ажил, сонирхол хүсэлтийг харгалзан, дугуйлан семинарт шат ахмулан хувиарлах, дугуйлан онолын семинарын зохион байгуулалтыг нарийн хийх нь намын үүр хороодын гүйцэтгэвэл зохих үүрэг болж байна. Намын гэгээрлийн хичээлийн шинэ жилд тавих нэг үндсэн зорилт бол гишүүд орлогч гишүүдийг дугуйлан онолын семинарт бүрэн хамрахын гадна тэдэнд улс төрийн боловсролыг үйлдвэрлэл-эдийн засгийн сургалттай хослон эзэмшүүлэх, практик даалгаврын биелэлт үр нөлөөг сайжруулах хэрэгтэй.

Дугуйлангийн сонсогчдоор марксизм-ленинизмийн эх зохиолыг гүнзгий судлуулж тэдний бие даасан ажиллагааг идэвхижүүлэх, суртал нэвтрүүлэгч, сонсогчдод тусламж болгосон материалыг сонин хэвлэлд өргөн бичих, клуб, улаан булан, номын сан зэрэг газарт үзүүлэн хийж тавих, дугуйлангийн онолын семинарыг программын дагуу сонсогчдын уншвал зохих номын нэрсийг гаргаж булан гаргах зэрэг ажлуудыг хийх хэрэгтэй.

Суртал нэвтрүүлэгчдийг хичээлдээ бэлтгэх боломцоо олгож, туршлага солилцох зөвлөгөөн, нээлттэй хичээл хийх, суртал нэвтрүүлэгчдэд эзэмшүүлэх туршлагын цуглуулга хийж судлуулах зэрэг ажил зохиох нь зүйтэй. Дугуйлан, сонсогчдын ажиллагаа идэвхи оролдлогын талаар намын үүр, хороод байнга шалгаж, товчооны ба бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж тодорхой зөвлөлгөө туслалцаа өгч байх хэрэгтэй. МАХН—ын XV их хурлын шийдвэр ба МАХН—ын программ судлуулах энэ талаар консультац зөвлөлгөө өгөх онолын бага хурал хийх зэрэг ажлуудыг төлөвлөгөөтэй явуулж байвал зохино. Нөгөө талаар эвлэл, үйлдвэрчний шугамаар зохиогдож буй дугуйлан семинарын эхлэлт, зохион байгуулалт явцад байнга хяналт тавих ялангуяа суртал нэвтрүүлэгч нараар нэр хүндтэй, туршлагатай хүмүүсийг томилох зэргээр тодорхой удирдан чиглүүлж байх нь намын байгууллага бүрийн үүрэг болж байна.

Намын гэгээрлийн 1966—67 оны хичээлийн жилийн хүмүүжил олон түмний ажилд намын байгууллагуудын удирдах хүмүүс сэхээтэн нарыг өргөнөөр оролцуулах явдал намын үүр хороодын анхааран ажиллах чухал зорилт мөн.

Я.Лувсанпунцаг

## Москвагийн мах комбинатад хийсэн тэмдэглэл

ЗХУ—ын нийслэл Москва хотдахь Останкинсийн мах комбинат бол их хотод оршин суугчдын гуравны нэг хувийг махан бүтээгдэхүүнээр хангадаг томоохон комбинатын нэг юм.

Энэ комбинат 3 том заводтай бөгөөд 3500 гаруй ажилчидтай аж. Энэ комбинат 300 тонн мах боловсруулан гаргадагийн дотор 180 тонн болсон мах, 80 орчим тонн банш бас олон нэр төрлийн хиам хийдэг байна.

Уул комбинатын бүх ажлын 50 гаруй хувь нь механикжсаны дотор банш хийх ажил өвч бүрэн механикжсан байлаа. Энэ комбинат 6 давхар барилгатай бөгөөд барилгын 5 дахь давхараас эхлэн үйлдвэрлэлийн ажиллагаа явагддаг байна.

Тус комбинатын банш хийх машин 1 ээлжинд 8 тонн баншны мах хөшиглөх ба мөн баншны гурил зуурах, банш чимхэх, хайрцаглаж савлах, баншны хольц найрлага тохируулах зэрэг бүх ажил техникийн хүчээр хийгдэж байгаа нь нэн сонирхолтой байлаа. Биднийг очих үеэр уг комбинатынхан Русские пельмени (орос банш) хийж, түүнийг 350 граммаар хайрцаглаж байв.

Ер нь энэ комбинатын ажилчдын ихэнх нь залуучууд байдгийн дотор бүх ажилчдын 65 хувь нь эмэгтэйчүүд ажилладаг байна.

Тус комбинат нь 1954 онд анх байгуулагдсан бөгөөд одоо коммунист хөдөлмөрийн комбинат болох зорилт тавиад ажиллаж байгаа гэнэ. Бас энэ комбинат өөрийнхөө ажилчдад үйлчлэх биеийн тамирын болон соёлын орд, хурлын танхим, хүүхдийн цэцэрлэг, ясли, пионерийн зуслан зэрэг соёл үйлчилгээний олон газрууд ажилладгаас гадна 8 их эмчтэй эмнэлэг үйлчилдэг байна.

Энэ комбинат өөрийн өмнө тавигдсан зорилтоо ямагт биелүүлдгийн дээр шинэ нэр төрлийн олон зүйл санаачлан хийж Коммунист Намын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн уралдаанд шилжих тугийг 2 дахь удаагаа аваад ажиллаж байгаа ажээ.

Б. Цэрэндаш

Москва. 1966—6—13

## ЗХУ—ын тогтмол хэвлэлээс

СССР—ийн Зохиолчдын Холбооны хэвлэл «Литратурная газета» нь тус орны утга зохиолын үйл явдал, амьдралтай уншигчдыг танилцуулна.

Сонин нь Мягмар, Пүрэв, Бямба гаригуудад гардаг. Тус сониноос эрхлэн утга зохиолын үндсэн асуудал болох социалист реализмын асуудлаар маргаан зохион явуулдагаас гадна хилийн чанадахь орны ба Зөвлөлтийн урлаг утга зохиолын амьдрал харилцаа холбооны тухай өгүүлдэг юм.

Коммунист нийгмийн байгуулалтанд олж байгаа ололт амжилтыг урлаг утга зохиолд тод томруун дүрслэн харуулахад тус сонины гол зорилго оршдог юм.

Уншигчид энэ сониноос сонирхолтой өгүүлэл, яруу найраг, янз бүрийн учрал, тохиолдол, орчин үеийнхний тухай дурьдатгал, зохиолчдын уран бүтээлийн зам, ах дүү бүгд найрамдах улсуудын зохиолчдын ажил амьдралтай танилцаж болно. Сонины хуудсанд Зөвлөлт болон гадаад орны зохиолчдоос хийж байгаа зохиол бүтээлийн талаар өгүүлнэ.

Утга зохиол сонинд Зөвлөлтийн ба хилийн чанадахь орны зохиолчдын замын тэмдэглэл, найруулал, богино хэмжээний өгүүлэлийг байнга нийтэлж байдаг.

Утга зохиол сонин жилд 156 дугаар гардаг.

ЗХУ—ын соёлын яам, соёл гэгээрлийн үйлдвэрчний Төв Хорооны хэвлэл «Советская Культура» сонинд Зөвлөлт холбоот улсын соёл утга зохиолын үйл амьдралын тухай өргөн дэлгэр нийтэлдэг.

Шинэ опер, балет, жүжиг Зөвлөлтийн урлагийн нэрт зүтгэлтнүүдийн уран бүтээлийг хэлэлцдэг. Сонины хуудсанд Зөвлөлтийн театрын хамт олноос Европын орнуудад болон Америк, Ази, Африк, Австралд очиж тоглосон тухай хилийн чанадахь орны урлагийн нэрт зүтгэлтнүүдээс Москва, Ленинград, Киев Тбилис болон ЗХУ—ын бусад хотуудад тоглосон тухай олон тооны өгүүлэл нийтлэгдэж байна.

Сонины хуудсанд урлаг уран сайхан хөгжим киноны урлагт өндөр бүтээл гаргаж Лениний шагналд нэр дэвшигчдийн ажлын тухай, үндэсний урлаг, утга зохиолын 10 хоногийн дүн, бүгд найрамдах улс, мужийн театрын хамт олны бүтээлийг хэлэлцэж байдаг юм.

Сонинд бүх холбоотын сайн дурын уран сайханчдын үзлэг, Зөвлөлт Холбоот Улсад мэргэжлийн бус хамт олны урлагийн хөгжилт улам олширч байгаа талаарх ажлын тухай нийтлэнэ.

Сонинд гадаад орнуудтай соёлын харилцааг хөгжүүлэх асуудлын талаар тусгаж байдаг юм.

Зөвлөлтийн соёл сонин нь жилд 156 дугаар гарна.

* * *

ЗХУКН—ын Төв Хорооны 7 хоногийн хэвлэл «Экономическая газета» нь улс ардын аж ахуйн зарчимч удирдлага эдийн засгийн хуулийн хөгжилд дүн шинжилгээ хийж, аж үйлдвэр хөдөө аж ахуйн хөгжлийн чухал асуудлыг тусгадаг юм. Улс ардын аж ахуйн удирдлага төлөвлөлтийн талаар нэрт эрдэмтэд, эдийн засагчид, мэргэжилтнүүд олон тооны асуудлыг тус сонины хуудсаар дамжуулж хэлэлцэж байдаг юм. Уншигчид хөдөлмөрийн зохион байгуулалт, удирдлагын тухай шинжлэх ухааны асуудлын талаар цоо шинэ мэдээсэлтийг олж үзэж болно. Сонинд үйлдвэрийн зохион байгуулалт, үйлдвэрийн ажиллагааг улам сайжруулж байгааг, үйлдвэрийн эдийн засгийн ололтын тухай өгүүлнэ. Сонин нь үйлдвэрийн дарга, ерөнхий инженер, аж үйлдвэрийн газарт боловсон хүчний роль, шинэ техник нэвтрүүлж байгаа тухай техникийн дэвшлийн төлөө тэмцэлд зориулагдсан өгүүлэл нийтэлж байна.

С. Цэнд Орос хэлнээс товчлон орчуулав

## *Тоосгочин залуустай уулзахад*

**(Сурвалжлага)**

Шинэ өдрийн шижгэр бүтээлтэй золгуулсаар цагийн зүү 8-ын тоог заав.

Жаргалантын сангийн аж ахуйн тоосгоны бригадаар ороход 17—18 орчим насны охид, хөвгүүд эрэглэн ухсан нүхнээс шавар зөөцгөөх аж. Тэдний хийх ажлыг хувиарлан өгч байгаа залуутай уулзаж ажил төрөлтэй нь танилцвал.

—Манай бригад 1966 оны 6 дугаар сарын 19-нөөс эхлэн дунджаар 10—12 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж сангийн аж ахуйн бүх барилга засварт хэрэглэх болон Тал булагийн улаан буланг барих тоосго бэлдлээ.

Ер нь бааюучин Бадарч гуайгаас бусад нь 7—9 дүгээр анги төгсөөд санаалаараа ирж ажиллаж байгаа юм. Анх бид бааюуны мэргэжилтэн ганцхантай байсан одоо гуравтай болоод байна.

Дамдинпүрэв гэдэг жаал 2 удаа бааюуны өрлөг хийж 50 гаруй мянган тоосго шатаажээ.

Ганц ч гологдол гаргаагүй. Дамдинпүрэвийн дүү Даваасүрэн ахтайгаа хамт ажилладаг.

Ах дүү хоёр сар бүрийн нормоо 112—129 хувиар биелүүлж ирсэн. Бид тоосго үйлдвэрлэх ажлаа 10 дугаар сарын 15-нд хааж прейс засах, цахилгаан мотор тавих, худгийн мотор байгуулж ус татах зэрэг бэлтгэл ажлуудыг хийнэ.

Манайхан 10 дугаар сард СХТ Бригад болохоор захиргаа нам олон нийтийн байгууллагад саналаа тавьсан дэмжигдэж байгаа гэж ярив. Бас талын аргаар тоосго шатаах бэлтгэл хийж байгаа залуу Дамдинпүрэвтэй уулзаж яриа дэлгэхэд:

—Би өнгөрсөн хавар 9 дүгээр анги төгсөөд саналаараа ирж тоосгочин болсон.

Өдөртөө 220—230 тоосго хийдэг. Сүүлийн үед бааюу өрөх шатаах ажил хийж байна.

Ер нь өдөрт 5000 тоосго өрөх нормтой харин би 10000 тоосго өрдөг ба сард дунджаар 620 төгрөгийн цалин авдаг гэж сургуулийн ширээнээс гарсан тэр залуу ажилчин ажил амьдралынхаа тухай ярилаа.

896 хүн өдрөөр 1063 хүн өдрийн ажил хийж 452 мянган тоосго үйлдвэрлэсэн тоосгоны энэ бригад цаашдаа нэг ээлжинд 10 мянган тоосго гаргах чадалтай ЗХУ—ын төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон механикжсан бригад болох аж.

М. Цэрэндорж

## *Хөдөлмөрийн цуваа*

Баянжаргалан сумын Мөндбаяр даргатай МХЗЭ—ийн үүр аймгийн МХЗЭ—ийн 12 дугаар бага хурлыг угтаж өвс хадах, тарвага агнах, өвлийн түлш бэлтгэх залуучуудын хөдөлмөрийн цуваанууд гаргажээ.

Хөдөлмөрийн энэ цуваагаар МХЗЭ—ийн гишүүд залуучууд 17 кубметр мод бэлтгэж, 10 гаруй эмнэг морьдыг машин тармуурт сурган 200 гаруй тонн өвс хадаж, 2 тонн гаруй таана түүжээ.

Мөн пионер сурагчдын цуваа 120 тарвага агнаж, 1 тонн өвс хураан авсан байна.

Ч. Чанцал

* * *

Борнуур сангийн аж ахуйн ХБ анги 1965 оноос 1966 оны өр авлагыг 68,8 хувиар багасгаж, 1966 онд 2 сая хоёр зуун тавин мянган төгрөгийн бараа борлуулах төлөвлөгөөтэйгээс хагас жилийн хээ төлөвлөгөөг 2 хоногийн өмнө 104 хувиар, ном худалдаалалтыг 108,4 хувиар биелүүлж одоо жилийнхээ төлөвлөгөөг 5-аас 10 хоногийн өмнө биелүүлэх зорилт тавин ажиллаж байна.

П. Цэен

* * *

Бүрэн сум нэгдэл 1966 оны тарваганы арьс тосны төлөвлөгөөгөө биелүүлэв. Анчин Гунгаа 1500, Дэмбээ, Бардаа нар 500—700 тарвага агнах гэрээ хийж гэрээгээ давуулан биеүүлээд одоо зурам агнаж байна.

*Манай идэвхтэн*

## ЗАРЛИГИЙН ЗААЛТЫГ БИЕЛҮҮЛЬЕ

Бүрэн сумын намын үүр, АДХГ Захиргаа, БНМАУ—ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 169,170 дугаар зарлигуудыг төв, хөдөөгийн нийт хөдөлмөрчдийн хурал, цуглаан, улс төрийн сонсгол, айл өрхүүдээр таниулах ажил зохиож байгаа боловч уг зарлигуудыг амьдралд хэрэгжүүлэн биелүүлэх талаар тус сумын албан газрын дарга эрхлэгчид муу анхаарч байна. Ажилчин албан хаагчдын ажлын хариуцлага сахилга батыг сайжруулах талаар намын үүрийн бүх гишүүдийн өргөтгөсөн хурлаар энэ онд 2 удаа хэлэлцэж 3-аас дээш ажилчидтай албан газар бүр цагийн бүртгэлтэй болж түүнийгээ хатуу баримтлаж байхаар заасныг нэгдлийн ерөнхий хороо, ХБ анги ор нэрийн төдий хөтлөж бусад албан байгууллага огт хөтлөхгүй байна.

Иймучраас сумын аль ч байгууллагын хүмүүс ажлыг цаг минутаар таслаад зогсохгүй хэдэн өдөр хоногоор таслах, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэхгүй байх явдал ердийн хэрэг болжээ. Иймд тус сумын албан байгууллага бүр удирдлагаа төвлөрүүлж ажилчин албан хаагч нэг бүртэй ажиллаж ялангуяа Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 169, 170 дугаар зарлигуудын заалтыг амьдралд хэрэгжүүлэн биелүүлэх явдал чухал байна.

Д. Найдан